



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/120-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689 Цахим хаяг: ts.nadiiii@yahoo.com |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-----|
| 1.Төрийн аудитын санал, дүгнэлт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 10 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 11 |
| 3.Аудитын тайлан..... | 13 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 13 |
| 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 13 |
| 3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал..... | 14 |
| 3.4. Материаллаг байдал..... | 14 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 15 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... | 15 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 16 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 167 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 17 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 17 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 18 |
| 4.2 Албан шаардлага, зөвлөмж..... | 18 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХНХС | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд |
| ХНХЯ | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам |
| БСГ | Боловсрол соёлын газар |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА**

2022.02.25 № СЭА-2022/120-НА-СТА-ТШЗ

танзай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| □□□□ □□ □□□ | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------------|---------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 43,463,307.81 | 45,657,062.81 |
| 31 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,463,307.81 | 45,657,062.81 |
| 354 | Хангамжийн материал | 43,463,307.81 | 45,657,062.81 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 458,000.00 | 578,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,398,062.81 | 22,588,017.81 |
| 35460 | Хүнсний материал | | 120,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,607,245.00 | 22,370,645.00 |
| 356 | Мал амьтад | - | - |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 705,643,145.62 | 697,301,548.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 705,643,145.62 | 697,301,548.51 |
| 392 | Биет хөрөнгийн дүн | 696,331,145.62 | 687,739,548.51 |
| 39201 | Барилга байгууламж | 680,688,762.90 | 679,136,448.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (29,377,494.96) | (60,307,304.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 38,509,747.00 | 40,882,848.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,410,605.12) | (5,610,749.83) |
| 39207 | Тавилга, эд хогшил | 53,073,029.46 | 51,480,102.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (31,662,752.50) | (28,613,110.74) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 3,093,000.00 | 1,084,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (2,989,898.92) | (103,101.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,234,713.00 | 13,234,713.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,323,471.24) | (3,970,413.72) |
| 39217 | Ном | 496,116.00 | 526,116.00 |
| 393 | Биет бус хөрөнгийн дүн | 9,312,000.00 | 9,562,000.00 |
| 39301 | Программ хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (250,000.00) | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,312,000.00 | 9,312,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 749,106,453.43 | 742,958,611.32 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 749,106,453.43 | 742,958,611.32 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 749,106,453.43 | 742,958,611.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 202,588,074.46 | 202,588,074.46 |
| 51101 | Өмч: -төрийн | 202,588,074.46 | 202,588,074.46 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 59,006,135.75 | 52,858,293.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 59,006,135.75 | 59,006,135.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (6,147,842.11) |
| 51300 | Дахин үнэлгээний зөрүү | 487,512,243.22 | 487,512,243.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН | 749,106,453.43 | 742,958,611.32 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 505,881,247.60 | 453,558,460.86 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 98,448,306.00 | 36,719,260.86 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 98,448,306.00 | 36,719,260.86 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 98,448,306.00 | 36,719,260.86 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 98,448,306.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 36,256,014.86 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 463,246.00 |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 407,432,941.60 | 416,839,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 375,273,200.00 | 379,941,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 13,897,700.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 361,375,500.00 | 379,941,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 255,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 255,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 32,159,741.60 | 36,642,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,159,741.60 | 36,642,900.00 |
| 2 | Үйл ажиллагааны зардал | 411,583,086.23 | 459,444,081.37 |
| 21 | Урсгал зардал | 411,583,086.23 | 459,444,081.37 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 379,277,070.26 | 448,532,281.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 264,786,019.35 | 300,908,258.29 |
| 210101 | Үндсэн цалин | 185,580,257.40 | 255,966,100.34 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 60,626,394.78 | 26,734,202.06 |
| 210104 | Урамшуулал | 18,579,367.17 | 18,207,955.89 |
| 2102 | Нийгмийн даатгалын шимтгэл | 33,057,324.68 | 39,289,381.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 22,521,314.37 | 27,286,071.17 |
| 210202 | тэтгэмжийн даатгалын | 2,649,183.11 | 3,030,805.11 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,105,468.27 | 2,394,403.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 521,748.86 | 592,091.10 |
| 210205 | ЭМ-ийн даатгалын | 5,259,610.07 | 5,986,010.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,355,541.60 | 36,120,000.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,072,987.60 | 5,445,143.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 26,152,954.00 | 29,570,257.00 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,129,600.00 | 1,104,600.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,578,940.00 | 2,668,771.00 |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 125,400.00 | 91,200.00 |
| 210404 | Тээвэр шатахуун | 315,200.00 | 264,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн зардал | 79,000.00 | 733,780.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 82,700.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,383,600.00 | 1,066,591.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал | 675,740.00 | 429,900.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 2105 | Нормативт зардал | 17,113,840.00 | 20,724,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,051,340.00 | 20,652,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,500.00 | 72,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,304,800.00 | 1,076,300.00 |
| 210604 | Урсгал засварын зардал | 4,304,800.00 | 1,076,300.00 |
| 2107 | Томилолтын зардал | 72,900.00 | - |
| 210702 | Дотоодын томиллолт | 72,900.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс | 2,317,600.00 | 1,591,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 743,600.00 | 619,500.00 |
| 210802 | Аудит баталгаажуулалтын зардал | 324,000.00 | 972,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | |
| 2109 | Бараа, үйлчилгээний бусад зардал | 23,690,104.63 | 46,153,090.37 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 328,000.00 | |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,401,300.00 | 1,817,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,960,804.63 | 44,335,390.37 |
| 213 | Урсгал шилжүүлэг | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 3 | Үйл ажиллагааны үр дүн | 94,298,161.37 | (5,885,620.51) |
| 145 | Үйл ажиллагааны бус орлогын дүн | | |
| 225 | Үйл ажиллагааны бус зардлын дүн | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 262,221.60 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 262,221.60 |
| 4 | Үйл ажиллагааны бус үр дүн | - | (262,221.60) |
| 5 | Үйл ажиллагааны нийт үр дүн | 94,298,161.37 | (6,147,842.11) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 407,432,941.60 | 416,839,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 407,432,941.60 | 416,839,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 375,273,200.00 | 379,941,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 13,897,700.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 361,375,500.00 | 379,941,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 255,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 255,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 32,159,741.60 | 36,642,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,159,741.60 | 36,642,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 390,376,941.60 | 416,839,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 390,376,941.60 | 416,839,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 358,070,925.63 | 405,927,399.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 264,786,019.35 | 300,908,258.29 |
| 210101 | Үндсэн цалин | 182,360,257.40 | 223,143,502.40 |
| 210102 | Нэмэгдэл | 63,846,394.78 | 59,556,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 18,579,367.17 | 18,207,955.89 |
| 2102 | Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,057,324.68 | 39,289,381.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 22,521,314.37 | 27,286,071.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 2,649,183.11 | 3,030,805.11 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,105,468.27 | 2,394,403.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 521,748.86 | 592,091.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 5,259,610.07 | 5,986,010.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,330,541.60 | 36,120,000.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,072,987.60 | 5,445,143.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 26,152,954.00 | 29,570,257.00 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,104,600.00 | 1,104,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материал | 3,166,400.00 | 2,403,580.00 |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 97,900.00 | 113,800.00 |
| 210404 | Тээвэр шатахуун | 340,200.00 | 264,600.00 |
| 210403 | Шуудан холбооны зардал, мэдээлэл технологийн үйлчилгээ | 79,000.00 | 733,780.00 |
| 210404 | Ном | 13,000.00 | 82,700.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,460,000.00 | 1,003,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,176,300.00 | 204,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 16,408,940.00 | 21,608,780.00 |
| 210501 | Эм | 62,500.00 | 72,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,689,240.00 | 20,772,880.00 |
| 210503 | Нормын хувцас | 657,200.00 | 763,400.00 |
| 2106 | Эд хогшил урсгал засвар | 4,304,800.00 | 1,076,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,304,800.00 | 1,076,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 72,900.00 | - |
| 210702 | Дотоодын томилолт | 72,900.00 | |

| | | | |
|-------------|---|-----------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,388,200.00 | 2,606,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 814,200.00 | 1,634,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 972,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,555,800.00 | 1,915,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 709,500.00 | |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,846,300.00 | 1,915,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,306,015.97 | 10,911,800.30 |
| 3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 17,056,000.00 | - |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 4 | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | | |
| 5 | Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн | 3,158,300.00 | - |
| 22 | Хөрөнгийн зардал | 3,158,300.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 3,158,300.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,158,300.00 | |
| 6 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (3,158,300.00) | - |
| 7 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 8 | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 13,897,700.00 | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны үр дүн |
|---|---------------------------------|-----------------------|----------------------|--------------------------------------|
| А | 1 | 2 | 3 | 4 |
| 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | -21,394,325.62 | 749,106,453.43 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 80,400,461.37 | 80,400,461.37 |
| 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 59,006,135.75 | 749,106,453.43 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (7,162,342.11) | (7,162,342.11) |
| 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 51,843,793.64 | 741,944,111.32 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|----------------|----------------|---------------|-------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 418,175,800.00 | 405,467,599.70 | 12,708,200.30 | 97.0 |
| 21 | Урсгал зардлын дүн | 418,175,800.00 | 405,467,599.70 | 12,708,200.30 | 97.0 |
| 210 | Бараа үйлчилгээний зардал | 418,175,800.00 | 405,467,599.70 | 12,708,200.30 | 97.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 304,717,100.00 | 300,908,258.29 | 3,808,841.71 | 98.8 |
| 210101 | Үндсэн цалин | 223,961,900.00 | 223,143,502.40 | 818,397.60 | 99.6 |
| 210102 | Нэмэгдэл | 59,556,800.00 | 59,556,800.00 | - | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 21,198,400.00 | 18,207,955.89 | 2,990,444.11 | 85.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,912,200.00 | 39,289,381.41 | 1,622,818.59 | 96.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,723,600.00 | 27,286,071.17 | 1,437,528.83 | 95.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,047,200.00 | 3,030,805.11 | 16,394.89 | 99.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,437,700.00 | 2,394,403.97 | 43,296.03 | 98.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 609,400.00 | 592,091.10 | 17,308.90 | 97.2 |
| 210205 | ЭМД-ын хураамж+В21 | 6,094,300.00 | 5,986,010.06 | 108,289.94 | 98.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 37,916,400.00 | 36,120,000.00 | 1,796,400.00 | 95.3 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 6,978,800.00 | 5,445,143.00 | 1,533,657.00 | 78.0 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 29,833,000.00 | 29,570,257.00 | 262,743.00 | 99.1 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,104,600.00 | 1,104,600.00 | - | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,947,200.00 | 1,943,780.00 | 3,420.00 | 99.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 113,800.00 | 113,800.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо | 264,600.00 | 264,600.00 | - | 100.0 |
| 210404 | Ном | 737,200.00 | 733,780.00 | 3,420.00 | 99.5 |
| 210405 | Хог хаягдал | 82,700.00 | 82,700.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 748,900.00 | 748,900.00 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 26,969,200.00 | 21,608,780.00 | 5,360,420.00 | 80.1 |
| 210501 | Эм | 72,500.00 | 72,500.00 | - | 100.0 |
| 210502 | Хоол хүнс | 26,133,300.00 | 20,772,880.00 | 5,360,420.00 | 79.5 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 763,400.00 | 763,400.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,076,300.00 | 1,076,300.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,076,300.00 | 1,076,300.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 116,300.00 | - | 116,300.00 | 0.0 |
| 210702 | Дотоод томилолт | 116,300.00 | - | 116,300.00 | 0.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 2,606,000.00 | 2,606,000.00 | - | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 1,634,000.00 | 1,634,000.00 | - | 100.0 |

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|--------|---|----------------|----------------|--------------|-------|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | 972,000.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,915,100.00 | 1,915,100.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,915,100.00 | 1,915,100.00 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | - | - | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | - | - | - |
| | Бусад хөрөнгө | | | - | - |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 418,380,600.00 | 416,584,200.00 | 1,796,400.00 | 99.6 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 379,941,300.00 | 379,941,300.00 | - | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,941,300.00 | 379,941,300.00 | - | 100.0 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 38,439,300.00 | 36,642,900.00 | 1,796,400.00 | 95.33 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 38,439,300.00 | 36,642,900.00 | 1,796,400.00 | 95.33 |
| 001 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | - | - |
| 002 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 003 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 39.00 | 39.00 | - | 100.0 |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтан | 32.00 | 32.00 | - | 100.0 |
| | Үйлчлэх ажилтан | 6.00 | 6.00 | - | 100.0 |
| 010 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/ | 148.00 | 128.00 | 20.00 | 86.5 |
| 015 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 148.00 | 128.00 | 20.00 | 86.5 |
| 024 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | - | - |
| 028 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 27.00 | 27.00 | - | 100.0 |
| 033 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 12.00 | 12.00 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | Зөрүү |
|------------|--|----------|------------|--------------|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | | 255,000.00 | (255,000.00) |
| 21 | Урсгал зардал | | 255,000.00 | (255,000.00) |
| 210 | Бараа ажил үйлчилгээний зардал | | 255,000.00 | (255,000.00) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 255,000.00 | (255,000.00) |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 255,000.00 | (255,000.00) |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 255,000.00 | (255,000.00) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн тайлан | | 255,000.00 | (255,000.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 255,000.00 | (255,000.00) |

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн *Ицаашид Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг гэх* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь *“Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая.”* гэсэн зорилготой, тухайн зорилгын хүрээнд 5 зорилт тавин ажилласан байна.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургалтын өмнөх боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д-НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон, Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 411,583.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,115.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,881.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,147.8 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөг/ |
|---|------------------|------------------|------------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Хувь хүнээс авах авлага | | | |
| Татаас санхүүжилтийн авлага | | | |
| Байгууллагаас авах авлага | | - | - |
| Урьдчилж төлсөн зардал | | | |
| Бараа материал | 43,463.3 | 45,657.1 | 2,193.8 |
| Үндсэн хөрөнгө | 705,643.1 | 697,301.5 | (8,341.6) |
| Нийт хөрөнгө | 749,106.4 | 742,958.6 | (6,147.8) |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 749,106.4 | 742,958.6 | (6,147.8) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 749,106.4 | 742,958.6 | (6,147.8) |

Бараа материалын дансны үлдэгдэл 45,657.1 мянган төгрөг болж 2,193.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн аж ахуйн материал, бичиг хэргийн материал, хүнсний материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 795,906.2 мянган төгрөг болж өмнөх оноос 2,751.1 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-наас 4,736.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, БСУГ-аас 30,0 мянган төгрөгийн /ном/ хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, хөрөнгийн үнэлгээг 5,964.8 мянган төгрөгөөр бууруулан, сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 58 дугаар тогтоолоор 5,964.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 741,944.1 мянган төгрөг болж 7,162.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 453,558.5 мянган төгрөг болж өмнөх оноос 52,322.7 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 459,444.1 мянган төгрөг болж өмнөх оноос 47,861.0 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 492,621.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 74,240.6 мянган төгрөгөөр бууруулж, **418,380.6 мянган төгрөгөөр баталсан** байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **418,380.6** мянган төгрөгийн төсөв баталснаас 379,941.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 38,439.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 379,941.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,642.9 мянган төгрөг нийт 416,584.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 405,672.4 мянган төгрөгийг зарцуулж, 10,911.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **405,672.4** мянган төгрөг буюу 97.0 хувьтай тайлагнагдсан байгаа нь тогтмол зардал 1,796.4 мянган төгрөгөөр, цалин, НДШ-ийн зардал 5,431.6 мянган төгрөгөөр, томилолтын зардал 116.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 5,360.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардлын санхүүжилт 255.0 мянган төгрөг төвлөрч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу цахим болон танхимын сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 418,380.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 405,672.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.0 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 4,766.0 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,573.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,014.5 мянган төгрөгийг залруулж, 183.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,375.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- 1,014.5 мянган төгрөгийн хүлэмж, зөгийн самбарыг шууд зардлаар бүртгэснийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Тус цэцэрлэгийн эрхлэгч Х.Өлзийсайханд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2, 4 дүгээр улиралд 51-54 хувиар тооцон 183.3 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.5 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн **15 хүртэл хувьтай тэнцэх** хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,375.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих **9** мэдээллийг хугацаа хоцроосон байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|---------|-----------|---------|---------------|-------|-----------------|-----|---------|---------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг | 3 | 2,573.0 | 1 | 1,014.5 | 1 | 183.3 | | | 2 | 1,375.2 |